



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Нэр бүхий зургаан хувьцаат компанийн
үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь аймгийн сум дундын шүүхийн холбогдох шийдвэрийг тус тус үндэслэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий зургаан хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Нэр бүхий зургаан хувьцаат компанийн хувийн хэрэг, холбогдох нотлох баримтыг журмын дагуу архивд шилжүүлэн хадгалуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай

3. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА




Д.БАЯРСАЙХАН

000396

Санхүүгийн зохицуулах хорооны

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
233 дугаар тогтоолын хавсралт



№	Компанийн оноосон нэр	Гаргасан хувьцааны тоо	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар
1	“Орхон жимс ногоо” ХК	410,459	Дархан-Уул аймгийн сум дундын шүүхийн 2005.06.30-ны 528 дугаар шийдвэр
2	“Асралт хайрхан” ХК	52,600	Сэлэнгэ аймгийн сум дундын шүүхийн 2011.12.09-ний 298 дугаар шийдвэр
3	“Монгол шүдэнз” ХК	50,784	Сэлэнгэ аймгийн сум дундын шүүхийн 2012.06.15-ны 323 дугаар шийдвэр
4	“Шинэс” ХК	28,564	Сэлэнгэ аймгийн сум дундын шүүхийн 2011.12.07-ны 292 дугаар шийдвэр
5	“Жавхлант хараа” ХК	58,543	Сэлэнгэ аймгийн сум дундын шүүхийн 2011.11.30-ны 742 дугаар шийдвэр
6	“Дээд буян” ХК	100,996	Дундговь аймгийн сум дундын шүүхийн 2006.11.13-ны 306 дугаар шийдвэр

--ooOoo---